



ӨЛЗИЙН РАВДАН

/Улаанбаатар хотын аймгийн дарга/
/1932.07.04-1932.08.27 /

Түшээт хан аймаг, Мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймгийн нутагт 1899 онд төрсөн. Сүүлдээ Завхан аймгийн Алдархаан сумын харьяат болсон. Багадаа цэрэгт харуулын алба хааж байхдаа Хатанбаатар Магсаржавт “Нууц бичиг” хүргэж Оросын цагаан цэргийн эсрэг байлдаанд оролцож явсан.

1922 онд Улиастай хотод ХЗЭ, МАХН-д гишүүнээр элсэн орж эвлэлийн үүрийн сурган боловсруулах ажил эрхэлж байгаад анхны хоршооны түүхий эдийн эрхлэгч, дарга, аймгийн намын хорооны зохиолын хэлтсийн эрхлэгч, улсын худалдааны газар болон хоршоодын төв холбооны ерөнхий хорооны дарга зэрэг алба хашиж байжээ.

1932 оны 7 дугаар сарын 4-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр тогтоолоор Улаанбаатар аймгийн даргаар томилогдож удалгүй өөр ажилд шилжин ажиллах болсон тул мөн оны наймдугаар сарын 27-нд Сайд нарын Зөвлөлийн есдүгээр тогтоолоор чөлөөлөгдсөн байна.

Тэрбээр МАХН-ын VIII их хурлаар Төв хорооны гишүүнээр сонгогдож, БНМАУ-ын VI, VII их хуралд төлөөлөгчөөр оролцсоноос гадна Улсын бага

хурлын гишүүнээр сонгогдож байжээ.

Ө.Равдан ажиллах хугацаандаа ангийн буу, дурангаар шагнагдаж байснаас гадна “Алтан гадас”, “Аж үйлдвэрийн гавьяаны одон”-гоор тус тус шагнагдаж байсан байна.

1936 оны есдүгээр сард хилс хэрэгт баривчлагдаж хожим БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх цагаатгалын комиссын 1962 оны хоёрдугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолоор цагаатгагджээ.